



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/41

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай


Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 47 дугаар тогтоол, “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1.4.6, Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/346 дугаар захирамж, тус газрын дүрмийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Сити тур” төслийн аудио хөтөч төхөөрөмжийг худалдан авах, сонгон шалгаруулалтаар сонгогдсон байгууллагатай гэрээ байгуулан ажиллахыг Дотоодын аялал жуулчлал, бүтээгдэхүүний хөгжил хариуцсан мэргэжилтэн /Б.Ишдорж/-д даалгасугай.

2. Аудио хөтөч төхөөрөмж худалдан авахад шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.


3. Төхөөрөмжийн үнэ 30,371,000 /гучин сая гурван зуун далан нэгэн мянган/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-т зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.БАТСҮХ

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 05
сарын 24 өдрийн А/41 дүгээр
тушаалын хавсралт



АУДИО ХӨТӨЧ ТӨХӨӨРӨМЖИЙН
ЗАРДЛЫН ТӨСӨВ

2018.05.24

Улаанхбаатар хот

№	Зардлын төрлүүд	Тоо ширхэг	Нэгжийн үнэ /НӨАТ/	Нийт
1	Аудио хөтөч төхөөрөмжийн хүлээн авагч	90	308,000	27,720,000
2	Аудио хөтөч төхөөрөмжийн дамжуулагч	2	319,000	638,000
3	Дамжуулагчийн микрофон	2	16,500	33,000
4	Хүлээн авагчийн чихэвч	90	6,600	594,000
5	Цэнэглэгч зөөврийн хайрцаг	2	693,000	1,386,000
Нийт дүн				30,371,000

--oo0oo--